



АРДЫН ИХ ХУРЛЫН ЗАРЛИГ

1965 оны 4 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар № 79

Улаанбаатар
 хот

Улаанбаатар хотод засаг захиргааны район байгуулах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүн сэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябрь, Төмөр замын хороодыг татан буулгаж, Ажилчны район, Найрамдлын район, Октябрыйн район, Сүхбаатарын районуудыг байгуулсугай.

Энэ зохион байгуулалтын өөрчлөлтийн ажлыг орон нутгийн хурлын 7 дахь удаагийн сонгуультай хамтран явуулсугай.

Октябрыйн район Барилгын техникумын зүүн талын засмал буюу Үндсэн хуулийн гудамжаар явж, Дунд голтой нийлж, Дунд голоор баруун тийш явж Туул голтой нийлнэ. Туул голын хойд эргээр явж Сонгино хайрхан уулын хяртай нийлнэ. Уул өөдөө Сонгино уулаар хярлаж, 22 -ын давааны хяртай нийлнэ. Чингэлтэй уулаар хярлан 75-ын энгэр рүү бууж, Тасганы овоогоор хярлаад Гэсэр сүмд хүрч Гандангийн хүр доогуур засмалаар явж Үндсэн хуулийн гудамжтай нийлнэ.

Хотын төв хэсгийг хамарсан Сүхбаатарын район-515 м² газар нутагтай

Хотын зүүн хэсгийг хамарсан Найрамдлын район-978 м² газар нутагтай


Хотын баруун хэсгийг хамарсан Октябрыйн район-396 м² газар нутагтай

Хотын өмнөд хэсгийг хамарсан Ажилчны район-344 м² гэж тус тус дурьдсан байна.

/Архивын материалыас/




ОКТЯБРИЙН РАЙОН
/1965-1992/



Октябрьин район нь анх 1965 онд засаг захиргааны 20 хороо, 12000 өрх, 63000 хүн амтай байгуулагдаж, **анхны даргаар Галдангийн Батаахаан томилогдон /1965-1973/ онуудад ажиллаж байв.**

БАЯНГОЛ ДҮҮРЭГ
/1992-2005/



Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 18-ны тогтоолоор Октябрьин район нь Баянгол, Сонгино-Хайрхан дүүрэг болж зохион байгуулагджээ. Баянгол дүүрэг нь газар нутгийн хувьд урд талаараа Хан-Уул дүүрэг, баруун хойт талаараа Сонгинохайрхан дүүрэг, хойт талаараа Чингэлтэй дүүрэг, зүүн талаараа Сүхбаатар дүүрэгтэй тус тус хил залган оршдог юм. Октябрьин районаас Баянгол дүүрэг болж шинээр зохион байгуулагдахдаа засаг захиргааны 19 хороо, 25.2 мянган өрх, 120.0 мянган хүн амтай, 2.9 га нутаг дэвсгэртэй байв.

Эдүгээ тус дүүрэг засаг захиргааны 20 хороо, 30834 өрх, 134457 хүн амтай орон сууцны хороолол төвлөрсөн үйлдвэрлэл, худалдаа, соёл үйлчилгээний томоохон дүүрэг болон хөгжих байна.